

“МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ”

С.Энхцэцэг*

1. Хятадын эдийн засгийн гадаад бодлогод гарч буй өөрчлөлт

Өнөөгийн Хятад улс нь дэлхийн хэмжээний их гүрэн /super power/ байхын гол шалгуур болсон улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын хөгжлөөрт эргүүлэх хэмжээнд хүрч байгааг дийлэнх орнууд хүлээн зөвшөөрч байна. Хятадын эдийн засаг, санхүүгийн хүч чадал, шинжлэх ухаан, технологийн чадавхи өсөн нэмэгдэж, зээл тусламжаар дамжуулан эеэр татах дипломат бодлогын үр дүнд хөрш орнууд болон хөгжиж буй орнуудын дунд Хятадын нэр хүнд дээшилж харилцааны түвшин сайжирсан нь бусад хөгжингүй орнуудын сэтгэлийг түгшээж байна.

Дэн Сяопины үеэс гадаад бодлогын гол уриа “*хүч чадавхаа нууж цагийг нь болтол хүлээх*” (*taoguang yanghui*) гэсэн үзэл саяхныг хүртэл үйлчилж байсан боловч 2014 оны 1 сард Хятадын ХКН-ын ЕНБД шинэ удирдагч Си Жинпин гадаад бодлого “санаачилгатай байх” (*fenfa you wei*) болсон талаар мэдэгдсэн нь Хятадын бодлого нэг шатнаас нөгөөд шилжиж гадаад бодлогын чиглэл, хандлагаа шинээр тодорхойллоо гэж үзэж байна. Хятадын эдийн засгийн хүч нөлөө өсөхийн хэрээр Бээжин олон улсын харилцаан дахь оролцоогоо нэмэгдүүлж байгааг онцлон тэмдэглэж байна. Хятадын шинэ гадаад хэргийн сайд Ванг Ви: “Хятадын дипломат бодлого *“итгэлтэй”, “тэсвэр хатуужилтай”, “уужим”* гурван шинжийг агуулдаг онцлогтой. Эдгээр шинжүүд нь тус бүрдээ гүнзгий утга илэрхийлнэ. Тодруулбал, итгэл төгс байдал эх газрын хүч чадавхи, хөгжил цэцэглэлтээс улбаатай бол тэсвэр хатуужил үндэсний бахархалаас, уужим сэтгэл эртний соёл иргэншлээс үүдсэн өөртөө итгэх үзэлтэй холбоотой юм.² Эндээс үзвэл Хятад уламжлалт үзэл суртал давамгайлсан бодлогоос улс орноо нэгтгэх, хөгжлөө түргэтгэх зэрэг цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого руу шилжиж байна гэж үзэхэд хүргэж байна.

Хүйтэн дайны дараахи 20 гаруй жилийн хугацаанд 1990-ээд оны

* МУИС-ийн ахлах багш, Ph.D., Enkhtsetseg@num.edu.mn

2 Shannon Tiezzi: “Wang Yi outlines Chinese foreign policy vision” www.diplomat.com

ЗХУ-ын задрал, 2000-аад оны уламжлалт их гүрэн байсан Португал, Испани, Франц, Их Британи болон АНУ-ын мандал бууралт зэргээс Хятад сургамж авсан нь түүний цаашдийн хэрэгжүүлэх бодлогод нөлөөлнө гэж үзэж байна. Түүний нэг илрэл нь сүүлийн 10-аад жилд Хятадын эдийн засгийн өсөлт дунджаар 10 гаруй хувьд байсан ч ДНБ-нд эзлэх батлан хамгаалахын зардлаа 2 хувиас хэтрүүлэхгүй байгаа нь АНУ-ын хувьд энэ үзүүлэлт 4,4 хувь, 1980-аад оны дунд үе хүртэл ЗХУ-д 13-14 хувьд хүрч байснаас үзвэл Хятад улсын ялгагдах онцлог юм. Ингэхдээ цахим болон сансрын шинэ төрлийн салбар, бага боловч хангалттай хүрэлцэхүйц цөмийн тогтоон барих хэрэгсэлд түлхүү анхаарч ШХАБ-ын хүрээнд хоёр болон олон талт гэрээ хэлэлцээр байгуулах, стратегийн хувьд чухал түншүүд болох Исланд, ОХУ, Зимбавье, Шри Ланк зэрэг улсуудтай ЧХХ байгуулж нягт хамтын ажиллагааг бүрдүүлж³ байна.

АНУ-ын нэрт судлаач эрдэмтэн Дэвид Лэмптон Хятадын хүч чадлын 3 төрх: хүч, мөнгө, оюун санаа хэмээгээд хүч чадлыг тулган хүлээлгэх, шагнаан урамшуулах, татан дагуулах 3 хэлбэрээр илэрхийлж болох бөгөөд товчхоноор буу зэвсэг, мөнгө хөрөнгө, үзэл санаа юм. Хятадын эрх баригчид энэ 3 чиглэлийг ижил түвшинд хөгжүүлэх, цэрэг, эдийн засаг, оюун санааны хүч чадлаа нэгэн зэрэг зузаатгах бодлого явуулж байна. Хятадын хүчин зүйлийг хэтрүүлэх, эсвэл дутуу үнэлэх аль аль нь маш аюултай бөгөөд Хятад том, чухал, эрчимтэй, олон орон хамтран ажиллахыг зорьж байгаа тул хүчээр шахах, эсвэл үл тоох бус, зөвхөн харилцах, зохицохоос өөр сонголт байхгүй гэдгийг цохон тэмдэглэсэн байна.⁴

ХКН-ын Төв хорооны ЕНБД Ху Жиньтао 2007 онд болсон ХКН-ын XVII их хуралд тавьсан илтгэлдээ БНХАУ-ын гадаад бодлогын гол асуудлаархи байр суурийг тодотгосон нь одоо ч хэрэгжиж байна. Үүнд:

1. Улс төрийн хүрээнд харилцан хүндэтгэх, эрх тэгш яриа хэлэлцээ хийх замаар олон улсын харилцааг ардчилах явдлыг хамтдаа урагшлуулах;
2. Эдийн засгийн талаар, давуу талаараа бие биеэ нөхөж, эдийн засгийн глобалчлалыг жигд хэн хэнд нь бүх талаар ашигтайгаар урагшлуулахын төлөө хамтран ажиллах;
3. Соёлын салбарт, харилцан дуурайлал авахын зэрэгцээ ялгаа

3 Anne-Marie Brady: “Chinese Foreign Policy: A New Era Dawn” www.diplomat.com

4 Д.Шүрхүү: XXI зууны эхэн үеийн БНХАУ-ын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа., БНХАУ-ын хөгжлийн чиг хандлага: амжилт ба сорилт ном., х.180

зөрүүг хэвээр хадгалан нийтлэг зүйлээ олж, дэлхийн олон ургальч байдлыг хүндэтгэн, хүн төрлөхтний соёл иргэншлийг урагшлуулан хөгжүүлэхийн тулд хамтран ажиллах;

4. Аюулгүй байдлын хувьд, харилцан итгэж, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, дайны бус тайван замаар олон улсын маргааныг шийдвэрлэж, дэлхийн энх тайван, тогтвортой байдлыг хамтдаа хамгаалах;

5. Байгаль орчныг хамгаалах талаар, харилцан тусалж, хүчээ нэгтгэн хүн төрлөхтөн оршин тогтнох чухал үндэс нэгэн өрх гэр дэлхий ертөнцөө хамтран хайрлан хамгаалах зэрэг болно.⁵

Гадаад бодлогын зорилтыг хангахын тулд хэрэгжүүлж буй XXI зууны Хятадын дипломат бодлогын стратегийн 4 чухал талыг Хятадын эрдэмтэн Чэнь Зехуа дараахи байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Их гүрнүүдтэй харилцааг сайжруулан зохицуулах, зонхилох их гүрнүүдийн хооронд гарч буй болзошгүй эрх ашгийн мөргөлдөөн үүсэхээс зайлсхийх, зөөлрүүлэх

- Хөрш орнуудтай тогтоосон харилцааг сайжруулан зохицуулах, тэдгээр орнуудын эрх ашгийн зөрчилдөөнийг зөөлрүүлэх

- “**хятадын аюул**” гэдгийг няцаан, хүйтэн дайны дараа үүссэн Хятадыг тогтоон барихын тулд олон улс эвсэх, болон “шинэ хүйтэн дайн” үүсэхээс сэргийлэх

- Энх тайвныг сахин хамгаалж, гадаадын тэргүүний техник-технологийг татан оруулж улс орны нийт хүч чадлыг өсгөн нэмэгдүүлэх зэрэг болно.⁶

Дээрхээс үндэслэн Хятадын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд **нэгд**, Хятадын их гүрнүүдтэй харилцах харилцаа; **хоёрт**, хөрш орнуудтай харилцах харилцаа; **гуравт**, хөгжиж буй орнуудтай харилцах харилцаа; **дөрөвт**, олон талт харилцаа, хамтын ажиллагаа; **тавд**, цэргийн болон зөөлөн хүчний (soft power) бодлого гэж үзэж болно.

2012 онд ХКН-ын XVIII их хурлаар дэвшүүлсэн “**Хятадын үндэсний сэргэн мандалт**” буюу хятад үндэстэнг сэргээх тухай алхам нь үндэсэрхэг хандлага, үзэл рүү хэлбийж байгааг шинэ, хуучин хоёр удирдагч аль аль нь хэлсэн үгэндээ дурьдсан нь дэлхий нийтийн анхаарлыг татав. Хятадын шинэ удирдагч Си Жиньпин хэлсэн анхны үгэндээ уламжлалт хандлагыг эвдэж хөгжлийн социалист ирээдүйн тухай биш “хятад” мөрөөдлийн тухай өгүүлсэн нь анхаарал татаж

5 Мөн тэнд., х.152-153

6 Мөн тэнд., х. 154

байна. Энэ үзэл санаа ямар агуулгатай болохоос төр, засгийн нэр хүнд болон Хятадын өнөөгийн тогтолцоо, тогтвортой хөгжил хамаарах тул “Хятад мөрөөдөл”-ийг нилээд хийсвэр үзэл санаа гэж Оросын судлаачид тэмдэглэж⁷ байна.

Хятад улс эдийн засгийн хөгжлийн хувьд 30 гаруй жил үргэлжиж буй Дэн Сяопиний санаачилсан “*нээлттэй байх бодлого*”, “*нэг улс хоёр систем*”-ийн үзлийн ачаар дэлхийн эдийн засгийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болсон төдийгүй түүний нэг хөдөлгөгч хүч болсон явдал юм.

Өөрчлөлт шинэчлэлтийн 30 гаруй жилийн хугацаанд БНХАУ-ын хөгжил дэлхийд гайхагдаж, эдийн засгийн өндөр өсөлтөө удаан хугацаанд хадгалж тогтвортой байна. 1978-1988 онд Хятадын эдийн засгийн жилийн дундаж өсөлтийн хурд 9 хувь байсан бол 1988-2012 онд жилийн дундаж өсөлтийн хурд 10 хувиас давж байгааг үндэс болгон 200 жилийн хугацаанд тавигдаж буй зорилгоо 2012 онд хуралдсан ХКН-ын 18 дугаар их хурлын илтгэлд тусгажээ. ХКН байгуулагдсаны 100 жил (2021 он)-ийн үед бүх талаар баян чинээлэг нийгмийг байгуулах, Шинэ Хятад улс байгуулагдсаны 100 жилийн ойгоор (2049 он) баян чинээлэг, ардчилсан, соёлт, энх тайванч орчин үеийн социалист орныг бүтээн байгуулах⁸ болно. Үүний дотор 2020 он гэхэд ДНБ болон хот, хөдөөгийн иргэдийн орлогыг 2010 онтой харьцуулахад 2 дахин өсгөнө. Мөн хятадын нэг хүнд ноогдох ДНБ 2012 онд 6000 доллар байгааг 2020 онд 12000 долларт хүргэхээр төлөвлөж байна. Энэ нь ирэх 7-8 жилийн хугацаанд Хятадын эдийн засгийн жилийн өсөлтийн хурд 8 хувьд хадгалагдаж 2020 он хүртэл тогтвортой хөгжиж чадвал Хятад улс нь хамгийн том эдийн засагтай орон болж өөрчлөгдөнө гэж алсын хараагаа тодорхойлжээ.

Хятадын эдийн засгийн хөгжлийг тодорхойлохдоо дэлхийн эдийн засгийн хөгжлийн зүтгүүр гэж үздэг ч дараахи томоохон эрсдэл тулгарч байгааг судлаачид онцлон тэмдэглэсээр байна. Үүнд:

1. Хятад нь нэгэнт дэлхийн хамгийн их үйлдвэрлэх салбарын төв болсноор эдийн засгийн хөгжилд эрчим хүч ихээр зарцуулах болсон тул талаар байгаль орчны дарамтад байдлыг үүсгэж, нөгөө талаар нөөц баялгийг олох гадаад зах зээлд түшиглэх

7 Ч.Батцэцэг, “ХКН-ын XIII Их хурал болон Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаархи Оросын эрдэмтэн судлаачдын байр суурь”, Олон улс судлал., 2013 №3 х.5-21

8 Б.Наран., “Хятад, Монгол хоёр улсын нүүрсний салбар дахь хамтын ажиллагаа, хэтийн төлөв” Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ., УБ, 2013 оны 4 сар

байдлыг нэмэгдүүлжээ. Үүнээс үүдэн 1999 оноос эхлэн Хятад улс эрчим хүч, нөөц баялгийг олохын тулд “Гадагш гарах” (go out strategy) стратеги хэрэгжүүлж, гаднаас нөөц баялгийн олон талт нийлүүлэлтийн зорилтыг биелүүлэх зорилготой. Энэ хүрээнд 2008-2012 онд нийт 552.8 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгийг оруулж, ашиглалтын бүтэц, тогтолцоог сайжруулан чанарыг дээшлүүлэхэд анхаарах болжээ. Гадаад орнуудад хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2007 онд 24.8 тэрбум ам.доллар байсан бол 2012 онд 77.2 тэрбум ам.доллар болж, жилд дунджаар 25.5 хувиар өссөн нэмэгдэв⁹ гэжээ.

2. Хятад улс эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийд тэргүүлж болох ч хөгжингүй орон болохын тулд асар их замыг туулах шаардлагатай гэж үздэг. Учир нь 1.3 тэрбум давсан хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд их хэмжээний орон сууц, зам, гүүр барьж байна. Энэхүү томоохон бүтээн байгуулалтад шаардлагатай зэс, төмөр, нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг гадаад орнуудаас их хэмжээгээр худалдаж авах нь тус улсын хувьд чухал болоод байна. 2010-2020 онд Хятад улсад шаардагдах газрын тосны 50-60 хувийг гадаад орнуудаас импортлох шаардлагатай байгаагаас гадна, төмрийн хүдрийн 34-52 хувь, зэсийн 72-82 хувь, хар тугалгын 45-52 хувь, цайрын 53-69 хувь, марганецийн 31-38 хувийг мөн импортлох шаардлагатай гэж судлаачид¹⁵ тооцоолжээ.
3. Барууны эдийн засагчид *“middle income trap”* буюу дундаж орлоготой орнууд тэр болгон хүн амынхаа орлогыг өндөр орлоготой шатанд дэвшүүлж чаддаггүй, янз бүрийн шалтгаанаас болж *“дундаж орлогын занга”*-нд орж нэг түвшинд гацах, бүр хойшоо ухрах зүй тогтол байдгийг онцолж үүнийг Хятадын эдийн засгийн хүчин зүйлтэй холбон авч үзэж байна. 2012 онд Хятадын нэг хүнд ногдох орлого нь 6000 ам.долларт хүрч дундаж орлоготой орнуудын эгнээнд багтах боллоо. Эдийн засгийн асар их хурдтай хөгжлийг дагалдан байгаль орчин, хүрээлэн буй орчны доройтол, хот хөдөөгийн ялгаа, хүн амын орлогын зөрүү, нийгмийн халамжийн асуудлууд хуримтлагдсан байгааг албан ёсоор хүлээн зөвшөөрч байна.
4. Өмнөх хөгжлийн загвар нь Хятадын хямд ажиллах хүчинд

9 Н.Төмөр., “Бүх Хятадын АТИХ-ын XII дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулган ба БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал” Олон улсын харилцаа сэтгүүл., 2013.№1 х.146-154

тулгуурласан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж, дэлхийн зах зээлд экспортлох, түүнээс олсон орлогоос баялагийг бүтээх хөгжлийн загвар байсан ч АНУ-ын санхүүгийн хямрал, Европын өрийн хямрал зэрэг гадаад хүчин зүйлсээс шалтгаалан Хятадын экспортын зах зээл хумигдсанаас цаашид энэхүү экспортод түшиглэсэн хөгжлийн загвар явцгүй болсон тул дотоод зах зээлдээ тулгуурлан эрэлтээ нэмэгдүүлэх, техникийн инноваци үйлдвэрлэлийг хөгжүүлэх шинэ хөгжлийн загварт шилжих нь зүйтэй¹⁰ гэдгийг хүлээн зөвшөөрч байна. ХКН-ын XVIII их хурлын тайланд өнөөгийн зах зээлийн эдийн засгийн бүтэц, хөгжлийн хэв загварын (growth model) өөрчлөлтийг шуурхайлах, шинжлэх ухаанчаар хөгжихийг уриалж, эдийн засгийн хөгжлийн шинэ загварыг бий болгох хэрэгтэйг онцлон заав. Хятадын онцлогтой орчин үеийн аж үйлдвэр, мэдээлэлжүүлэлт, хотжилт, ХАА-н өөрчлөлт, шинэчлэлтийг зэрэг хэрэгжүүлэх зорилт тавьжээ. Өнгөрсөн 30-аад жил бий болгосон Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар нь үеэ өнгөрөөсөн тухайд Оросын судлаач Сергей Лузянин “эдүгээ Хятад улс нь дорвигүй эдийн засаг, түрэмгий экспорт, технологийг хуулбарлан ашиглах явдалд тулгуурласан шинэ, хуучин загваруудын уулзвар дээр байна. Шинэ загвар дотоодын эрэлтийг ашиглах, дэлхийн инновацийн төвийг Хятад улсад байгуулах явдлыг түшиглэж байна. Үүнд: Хятад улс үндэстний сэтгэлгээтэй холбоотой тулгар асуудал гарлаа. Хятадууд бол хатуу сахилгатай маш сайн гүйцэтгэгч, зиндааг чанд баримтлагч, үйл явц, технологийг сайн хуулагч болохоо өмнөх хэдэн арван жил нотлон харуулав. Гэвч тэд бүтээлч үйл ажиллагааг систем болгоход сайн биш, бас дээр нь хариуцлага өөртөө ногдуулах, эрсдэлтэй боловч урагш ахих шийдвэрийг санаачилах дургүй” бөгөөд энэ бүхэн нь инноваци маягийн эдийн засаг Хятад улсад байгуулахад саад болно¹¹ гэжээ.

5. Өнөөдөр дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 1/5 хувийг дангаар хэрэглэж байгаа Хятадын эрчим хүчний салбар өсч байгаа хэрэглээгээ хэрхэн дотоод, гадаадын хязгаарлагдмал нөөцөөр тогтвортой хангах бодлого баримталж байгааг анхааралтай ажиглаж байна. Хятад улс эрчим хүчний нөөц дутмаг, тухайлбал,

10 Ц.Батбаяр., “ХКН-ын XIII их хурлаас 2020 он гэхэд дундаж чинээлэг нийгэм байгуулах зорилт дэвшүүлээ”. Олон улс судлал сэтгүүл., 2013 №1 (98) х.6 /5-10/

11 Ч.Батцэцэг., “ХКН-ын XIII Их хурал болон Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаархи Оросын эрдэмтэн судлаачдын байр суурь”. Олон улс судлал., 2013 №3 х.5-21

дэлхийн байгалийн хийн нөөцийн 7.1 хувь, газрын тосны нөөцийн 7.7 хувийг тус тус эзлэх бөгөөд өнөөгийн олборлолтын хүчин чадлаар тооцоолбол, газрын тосны нөөцийг 15 жил, байгалийн хийн нөөцийг 30 жилийн хугацаанд олборлож дуусах төлөвтэй. Хятад улсад шаардагдах газрын тосны барагцаалбал 50 хувийг гадаад орнуудаас худалдан авдаг¹². Иймээс сүүлийн жилүүдэд Хятад импортын хамаарлаа багасгахын тулд хийсэн үйл ажиллагааны гадаад, дотоод аль хүчин зүйлсийг нь харгалзан үзсэн 4 гол стратеги бодлого хэрэгжиж байна. Үүнд **нэгд**, импортын эх үүсвэрээ олон түвшин, сувагтай болгох чиглэлд хийсэн цогц алхамууд; **хоёрт**, дотоод нөөцөө ашиглах, хэрэглээг багасгах оролдлогууд; **гуравт**, төрийн байгууллагуудын зохион байгуулалт, удирдлагын хангалтыг сайжруулах шинэчлэлүүд; **дөрөвт**, тээвэрлэлтийн замыг нэмэх, бататгах, хамгаалах чиглэлүүдэд¹³ түлхүү анхаарч байна.

Хятад улс хөрш орнуудтай хоёр болон олон талт хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэхэд ихээхэн анхаарч санал санаачилга гаргаж байгаагийн нэг тод илрэл бол **“Торгоны замын эдийн засгийн бүс”** (Silk Road Economic Belt) болон **“Далайн торгоны зам”** (Maritime Silk Road) төслийг олон улсын хэмжээнд хөгжүүлэхэд идэвхитэй анхаарч байна. Австрали, Өмнөд Солонгос, Энэтхэг зэрэг хөрш томоохон орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахыг зорьж байна. Хятадын Төв Азийн улс орнуудтай холбогдох гол суваг нь салан тусгаарлах үзэл ихтэй Шинжааны бүс нутаг бөгөөд түүгээр дамжуулан эдийн засгийн хувьд харьцангуй сул хөгжсөн Төв Азийн байгалийн нөөцийг хүртэх төдийгүй, Хятадыг Европ, ОХУ, Ойрхи Дорнодын бүс нутагтай холбох гол гарц болж Шинжааны бүс нутагт эдийн засгийн үсрэнгүй хөгжлийг бэхжүүлж удаан хугацааны тогтвортой байдлыг бүрдүүлэх давхар ач холбогдолтой гэж үзэж байна.¹⁴

Хятадын хөршүүдтэйгээ харилцах харилцааны хүрээнд Монгол улстай харилцах асуудал түлхүү хөндөгдөнө. Хятад улс ус, хуурай газраар 30 орчим улстай хил залган оршдогоос 14 улстай шууд хиллэдэг. Улс төрийн талаас, хөрш орнууд бол улс орны бүрэн эрх, ашиг сонирхолыг хамгаалах, олон улсын тавцанд гүйцэтгэх үүргийг харуулахад чухал түшиг тулгуур, эдийн засаг талаас шинэтгэл, **нээлттэй бодлогыг** хэрэгжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагаа 12 Мөн тэнд., х.

13 Б.Отгонбаатар, “Хятадын эрчим хүчний аюулгүй байдал ба импортын хамаарал” Олон улс судлал сэтгүүл., 2013 №1 (98) х.48, 52

14 Shannon Tiezzi: “Wang Yi outlines Chinese foreign policy vision” www.

өрнүүлэхэд чухал түнш, аюулгүй байдлын талаас нийгмийн тогтвортой байдал, үндэстний зөвшилцөлд хөрш орнууд гадаад чухал хүчин зүйлийг бүрдүүлдэг гэж үздэг. Хөгжлөө түргэтгэх хүсэл эрмэлзэл, эдийн засгийн ашиг сонирхол нь Хятад- хөрш орнуудын харилцааны чухал хөдөлгөгч хүч болж байна.

Хятад, хөрш орнуудын харилцааны зангилаа асуудал бол харилцан итгэлцэл боловч итгэлцлийн үндэс суурь баттай биш байгаад Хятад судлаачид анхаарал хандуулж байна. Хятадын нэртэй эрдэмтэн Жан Юньлин: Хятад улс сэргэн өндийж буй өнөө үед хөрш орнууд Хятадын улам бүр хүчирхэгжиж буй нөлөөнөөс ихэд болгоомжлож байгаа нь **“хятадын аюул”** хэмээх номлолын үндэс болж байна. Хэрэв Хятад улс хил орчмын бүс нутагт хамтын ажиллагааны орчин бүрдүүлэхийг хичээж байгаа бол эн тэргүүнд Хятад, хөрш орнуудын хооронд жинхэнэ бодитой итгэлцэл бүрдүүлэх ёстой¹⁵ гэжээ.

Хятадын эдийн засаг, соёлын нөлөөг дамжуулах, зөөлөн хүчний бодлогын нэг томоохон суваг бол хятад иргэдийн шилжилт хөдөлгөөн, цагаачлал юм. Хятадууд аялал жуулчлал, боловсрол, бизнесийн шугмаар гадаад орнууд руу аялахад хориг саадгүй болсноор хүн ам цөөн, нягтшил багатай Монгол, ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын бүсэд сөргөөр нөлөөлж байна. Урьд өмнө ажил, амьдрал хайж цагаачилж байсан хятадуудын араас мөнгөө өсгөх гэсэн дунд ангийн жижиг бизнесменүүдийн том урсгал хөрш орнуудыг нөмөрч байна. Тэдэнд албан ёсны эрх, төр засгийн дэмжлэгээс гадна, ашиг орлогын хойноос хөөцөлдөх, хөрөнгө мөнгөө арвижуулахын тулд бүхий л арга сиймхийг ашиглах гэсэн мугуйд хүсэл эрмэлзлэл гадагш түлхэх гол хүч болж байна. Эдгээр жижиг бизнесменүүдийг даган тухайн орны байгаль, нийгмийн сэтгэл зүйд сөрөг нөлөө бүхий хятадын хоцрогдсон хөдөлмөрийн стандарт нөхцөл, шударга бус менежмент орж ирдэг¹⁶ нь бодитой юм. Судлаач Ц.Батбаярын тус улсын хүчин чадал, нөлөө улс төр, эдийн засаг, цэрэг арми, соёл зэрэг бүхий л чиглэлд эрчимтэй нэмэгдэж байгаатай уялдуулан **“Хятадын аюул”** хэмээх ойлголт тархах болсныг намжаах зорилгоор **“энх тайвнаар хөгжих”** гэсэн үзэл санааг гадаад бодлогынхоо ерөнхий зарчим болгож албан ёсоор зарлалаа¹⁷ гэж үзжээ.

Гэхдээ хол ойрын олон орнууд Хятад орныг аюул занал гэхээсээ илүүтэй том зах зээл, хөгжлийн боломж, цаг алдалгүй тэр боломжийг

15 Raffaello Pantucci and Alexandros Petersen: Tightening the Silk Road Belt www

16 Мөн тэнд., х.168-169

17 Мөн тэнд., х.182

ашиглах нь чухал гэж үзэх хандлага давамгайлж байна. Үүнд нөлөөлж буй цаг хугацаа, Хятадын зөөлөн хүч чадлын өсөлт /soft power/ ихээхэн нөлөөлж байгааг судлаач Д.Шүрхүү онцолжээ. Өөрөөр хэлбэл, Хятад улсын үсрэнгүй хөгжил хэр удаан үргэлжлэхийг хэн ч таамаглаж чадахгүй байгаа нь цаг хугацааны гол хүчин зүйл юм. Судлаачдын дунд нэг хэсэг нь өнөөгийн хөгжлийн эрчээ хадгалж чадвал дэлхийн эдийн засгийн супер гүрэн удахгүй болно хэмээн үзэж байхад нөгөө хандлага нь Хятад улс экологи, нийгэм, улс төрийн гүнзгий хямралд өртөж, зохистой харьцаа алдагдсаны улмаас дэлхийг хөлдөө чирэн нурах талаар ч дурьдаж байна. Иймд Хятадын үсрэнгүй хөгжлийг даган гарч ирж буй том зах зээлийг ашиглаж чадахгүй өнгөрөх, хөгжил урт хугацаанд үргэлжилбээс боломжийг ашиглахад цаг алдах, санаачлагаа бусдад алдах аюул Хятадтай харилцаж буй бүх улс орнуудад адил тулгарч байна.

Хятадын хөгжил түргэсэн дэлхий дахины бизнесийн үйл ажиллагаа тус орон руу чиглэх болсонтой уялдан хятад хэл, соёлын нөлөө ч өсөн нэмэгдэж Хятадын Засгийн Газар үүнийг бүхий талаар дэмжих бодлого явуулж байна. Ингэхдээ эдийн засгийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт зэргийг зөөлөн хүчний (soft power) эдийн засгийн хүчтэй, нарийн арга хэрэгсэл болгож байна. Зээл тусламж олгохдоо бусад хөгжингүй орнууд шиг нарийн болзол тавихгүй ердөө *“нэг Хятад”*-ын бодлогыг хүлээн зөвшөөрсөн байх шаардлага тавьдаг. Чөлөөт худалдааны хэлэлцээр, худалдааны тааламжтай нөхцөл олгох бодлогыг ч ялгавартай явуулж байна.

2. Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд Хятад улсын үзүүлэх нөлөө

Хятадын тав дахь үеийн шинэ удирдагч Си Жинпин БНХАУ-ын Дэд Ерөнхийлөгчөөр томилогдсоныхоо дараа 2008 онд гадаадад хийсэн анхны айлчлалаа Монгол Улсаас эхэлж байсныг, Хятадууд хөршүүдээ баян, амгалан, сайн гэж гурав хуваасан байх агаад Япон, БНСУ нь баян хөршүүд бол Монгол Улс сайн хөршид багтдаг нь өмнөд хөршийн зүгээс манай улсад хандах бодлогын чухал илрэл юм. Тиймээс манай улсын хувьд Хятадын талын “хөршөө хөгжүүлэх, хөрштэйгээ түншлэх” гэсэн чиг хандлага болон “Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал¹⁸”-д /1994, 2011/ Орос, Хятад хөрш хоёр улстай харилцах харилцааг тэнцвэртэйгээр хөгжүүлэх, гадаад харилцааг “эдийн засагжуулах” зарчмыг үндэс болгон бодлогоо

тодорхойлсон билээ.

Хүйтэн дайн дууссанаар Монголын геополитикийн орчин үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nuclear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*), мөн монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongols ethno-locked*) сул бүрхүүлтэй цоо шинэ геополитикийн орчинд Монгол үндэсний язгуур *эрх ашгийг дээдэлсэн, олон тулгуурт, бие даасан, нээлттэй* гадаад бодлого явуулах болсон нь том ололт мөн. Хөрш хоёр их гүрний асар том зах зээлийн эрэлт, хэрэгцээ, гадны сонирхлыг татаж буй уул уурхай, эрчим хүч, эрдэс баялгийн үлэмж нөөц зэргээс гадна Монгол Улс геополитикийн онцлог байршилдаа зохицон Ази-Европ тивийн хооронд иж бүрэн ложистик хангагдсан «газрын гүүр» болж, үүнийг аялал жуулчлалтай хослуулсан *идэвхтэй транзит* орон болох¹⁹ боломжтой. Тиймээс Монгол улсын өнөөгийн гадаад, дотоод орчин эрс өөрчлөгдөх болсонтой уялдуулан прагматик бодлого явуулж хөршүүдтэйгээ харилцан ойлголцлоо гүнзгийрүүлэх шаардлага нэн чухал байна.

Юуны өмнө хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлийг тодруулж авч үзэх хэрэгтэй юм. Хятад судлаач Чанг Бин хоёр улсын хоорондын харилцаанд таагүй нөлөөлж буй хүчин зүйлсийг дараахи байдлаар авч үзжээ.²⁰ Үүнд:

1. Хятад, Монголын хамтын ажиллагаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанаас эхлэлтэй бөгөөд эцсийн буух цэг нь ч мөн л эдийн засгийн хамтын ажиллагаа байна. “Монгол улс ОУХ-тай харилцаагаа хөгжүүлснээр улс төрийн тогтвортой байдлаа хадгалж, Хятадтай харилцаагаа хөгжүүлснээр эдийн засгийн тогтвортой байдлыг олж авах хэрэгтэй” гэж үздэг. Тиймээс Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаанд тогтвортой механизмыг бий болгож, Хятад, Монголын хооронд уламжлалт найрамдлыг хөгжүүлэх хэрэгтэй.

2. Тайванийн асуудлаар Монголын ЗГ ямагт эдийн засгийн ашиг сонирхолын үүднээс ханддаг.

3. Хятад улс аюулгүй байдлын үүднээс Монгол улсын Хятадыг боомилох хүсэлтэй цөөн их гүрний тулгуур багана болгохыг хүсэхгүй гэжээ. Учир нь Жикауны хиймэл дагуул хөөргөх төв, Таижуаны хиймэл дагуул хөөргөх төв, Ланксиний төмөр замын шугам зэрэг Хятадын умардын стратегийн 3 бүс байдаг Монголын хилээс 700 19 Д.Уламбаяр., “Монгол улсын геополитикийн орчны хувьсал: дүн шинжилгээ, эрдлийн магадлал” Олон улсын харилцаа сэтгүүл., 2013№1/26 (394) х.61-62

20 Чанг Бин: “БНХАУ, МУ-ын харилцаа, Хятад улсаас Монгол улсын талаар явуулж буй бодлого”, Стратеги судлал сэтгүүл 2009 х.132-138

км газарт байдаг нь улс төр, батлан хамгаалах бодлогын хувьд Умард Хятадын хилийн аюулгүй байдалд ноцтой сорилт, аюул занал учрах боломжтой хэмээн үзэж Хятадын зүгээс ихээхэн анхаардаг. Тиймээс Монгол улстай сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны харилцааг бүх талаар хөгжүүлэх нь Хятадын гадаад бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ямагт болсоор ирсэн төдийгүй Монгол улс гадаад бодлогын ямар ч стратеги баримтлалаа гэсэн Хятадад хор хүргэхгүй байх явдал туйлын чухал гэснээс үзвэл улс төр, цэрэг батлан хамгаалахын салбарт илтгэлцлэлийг бэхжүүлэх нь чухал байгааг харуулж байна.

Монгол-Хятадын харилцааг өнөөгийн шинэ агуулга, зорилго, нөхцөл байдалд тохируулан шинэлэг байдлаар хандах, хөрш том, жижиг орнуудын харилцан ашигтай түншлэлийн харилцааны загварын судалгааг эрчимжүүлэх, XXI зууны дэлхийн их гүрэн болж буй өмнөд хөршийн талаарх үзэл ойлголт, хандлагыг эрс өөрчлөх, хоёр талын харилцааг олон талаас нь шинэлэг хандлагаар эргэж харах шаардлага тулгарч байна.

1960 онд баталсан “Найрамдалт харилцан туслалцах гэрээ”-г шинэчилж 1994 онд “Хятад Монгол хоёр орны найрсаг хамтын ажиллагааны гэрээ”, 1998 онд “XXI зуунд чиглэсэн урт хугацааны тогтвортой, эрүүл, харилцан итгэлцлэлийн найрамдалт хамтын ажиллагаа”-г өргөжүүлэн 2003 онд “Сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа”-ны түвшинд хүргэсэн. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа бүх салбарт тэнцвэртэй хөгжихийг чухалчилан 2011 онд хоёр улсын харилцааг албан ёсоор “*стратегийн түншлэл*”-ийн харилцаа болгосон нь чухал алхам болов. Энэ хугацаанд өндөр дээд хэмжээний удирдагчдын харилцан айлчлал өргөжиж ирсэн явдал нь хоёр талын улс төрийн хүрээнд таатай уур амьсгалыг бүрдүүлж өгснөөр барахгүй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны стратегийн түншлэлийг улам идэвхижүүлж өгснөөрөө ач холбогдолтой юм.

Хятад-Монголын “*Стратегийн түншлэлийн харилцаа*” нь дараах 4 агуулгаас²¹ бүрдэнэ. Үүнд:

- ✓ Улс төрийн харилцаа болон харилцан итгэлцэлийг нэмэгдүүлж, хоёр талын харилцааны улс төрийн үндэс суурийг бэхжүүлэх;
- ✓ Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, хоёр улсын урт удаан харилцааны хөдөлгөгч хүчийг

21 Хуан Жякүй: “Шинэ цагийн Хятад-Монголын харилцаа” Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ., УБ, 2013 оны 4 сар

бий болгох;

✓ Хүмүүнлэгийн солилцоог нэмэгдүүлж, ард түмний найрамдалт харилцааг сайжруулан, хоёр ард түмний үзэл бодлын үндэс суурийг бэхжүүлэх;

✓ Олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа, стратегийн түншлэлийн харилцааны дотоод агуулгыг баяжуулах явдал юм. Хоёр тал эрдэс баялгийн олборлолт, дэд бүтэц, санхүү гэсэн 3 тал дээр хамтран ажиллаж **“Турван тал нэг бие”** зарчмыг улам бүр бодитоор хэрэгжүүлэх ёстой гэж Хятадаас Монголд сууж байсан элчин сайд асан Хуан Жякүй үзсэн нь тун чухал санаа юм.

Монгол-Хятадын эдийн засгийн харилцааг зохицуулагч гол механизм нь худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн Газар хоорондын комисс, мөн салбарын эдийн засгийн хамтын ажиллагааны Дэд комисс болон Ажлын хэсгүүд тухайлбал, ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар хоорондын Байнгын Зөвлөлдөх Ажлын хэсэг, Эрдэс баялагийн салбарт хамтран ажиллах Дэд хороо болон нүүрс, эрчим хүчний салбарт хамтран ажиллах ажлын хэсгүүд бөгөөд эдгээр нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.²² Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийн нэг нь уул уурхай, эрдэс баялагийн салбарын харилцаа, хамтын ажиллагааг “эрдэс баялагийн салбарт хамтран ажиллах дэд комисс” зохицуулах үүрэгтэй. Газрын тосны хайгуул, олборлолтын салбарт Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагаа нилээд өргөжиж байна. Монгол-Хятадын бүс нутаг, аймаг, мужууд болон салбар хоорондын шууд хамтын ажиллагаа идэвхижиж, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ), Евро-Азийн чуулга уулзалт (ASEM), Боаогийн Форум зэрэг бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа болон “Түмэн гол” төслийн хүрээнд хоёр талын харилцаа өргөжиж байна.

Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаанд газар зүйн байршил, эдийн засгийн хөгжил суурь нөхцлийг бүрдүүлж байна. Үүнд:

а/ газар зүйн байршил:

➤ Хамгийн урт хилийн шугам бүхий хөрш орнууд бөгөөд 14 хилийн боомттой

➤ Монгол улсын өргөн удам нутаг дэвсгэр, түүний хэвлий дор нуугдан буй эрдэс баялаг, Хятадын зах зээлд ойр орших давуу талтай шууд холбоотой. Чухам эндээс Хятадын хамгийн том зах зээлд байр

22 Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа х.445

сууриа эзлэх, харилцан ашигтай, хамааралтай оршин тогтнохын үндсэн нөхцөл болох Монгол улсын өрсөлдөх чадварыг өсгөн нэмэгдүүлэх асуудал урган гарч ирнэ²³.

➤ Монголын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн байршлаас үзвэл, Хятад бол тэргүүн сонголтын зорилтот зах зээл, хоёрдогч зах зээл нь Орос, Япон, Солонгос зэрэг ойр зэргэлдээх Зүүн хойд Азийн улс орон байх ёстой. Гуравдагч зах зээл нь ихэвчлэн нэн холын Европ, Америкийн хөгжингүй улсууд²⁴ байна гэж тэд үзэж байна.

➤ Монголын урагш түрж, Хятадын умард хэсэгт орших газарзүйн байршил нь аж үйлдвэрийн төв, зам тээврийн сүлжээнд холбогдох боломжтой байгаа нь экспортын бүтээгдэхүүний Хятадаар дамжуулан далайн боомт хүргэх давуу тал ч бас бий.

б/ эдийн засгийн харилцан нөхөх давуу тал:

➤ Хятадын нэн шаардагдлагатай 45 төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнээс 16 нь өөрийгөө хангаж дийлэхгүй болж, 15 төрлийн их оврын уул уурхайн бүтээгдэхүүний хомсдол нь тал хувьд хүрчээ. Монгол бол эрдэс баялгаар баян орон, нэгэнт илрүүлсэн эрдэс баялгийн төрөл 80 гаруй, ашигт малтмалын орд илрээц 6000 гаруй, нийт нөөц 50 тэрбум тонноос дээшээ байж, дэлхийд үндсэндээ 29-рт жагсдаг²⁵.

➤ Хятадын хувьд хөрөнгө мөнгө, технологи, менежментийн туршлага хэдийгээр хөгжингүй улс орныг гүйцэхгүй ч 2 тал энэ чиглэлээр хамтарч ажиллах боломж ихтэй.

Судлаач Д.Шүрхүү "...Хятадын зах зээлийн том тэлэлт байгаагүй бол Монгол улс дэлхийн геологи хайгуул, уул уурхайн салбарын анхаарал сонирхлыг татсан халуун цэг болж чадахгүй байсан боловуу. Орос-Хятадын стратегийн түншлэл гүнзгийрч худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин тэлж байгаа нь тэдний дунд орших Монгол Улсад газар зүйн байршлын давуу талаа ашиглах, хоёр том зах зээлийн бараа, бүтээгдэхүүний урсгалыг өөрийн нутгаар дамжуулан өнгөрүүлэх замаар тээвэр, зуучлал, үйлчилгээнээс орлого олох түүхэн нөхцөл бололцоо бүрдэж байна. Гагцхүү үүнийг богино хугацаанд бодит байдал болгох нь манай улсын засаг төрийн бодлогын алсын хараа, бизнесменүүдийн овсгоо, нийт монголчуудын хичээл зүтгэлээс

23 Д.Шүрхүү., "Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал ба БНХАУ-ын хүчин зүйл" Стратеги судлал № х.58

24 Б.Хөгжилт. Хятад, Монголын хамтын ажиллагааны харилцааны суурь нөхцөл, анализ Монгол, Хятадын уул уурхайн хамтын ажиллагаа сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, УБ, 2013

25 Мөн тэнд

их хамаарна...”²⁶ гэж үзжээ.

Мөн Монгол-Хятадын хил залгаа нутгуудад гол төлөв угсаа гарал, амьдрал ахуй, хэл соёл нэгтэй өвөр монголчууд тархан сууж байгаа нь худалдаа, эдийн засгийн төдийгүй, соёлын солилцоог өргөжүүлэхэд нэн чухал эерэг хүчин зүйл болж байна.

Өвөр Монголын өөртөө засах орны Монголтой залгаа хилийн урт 3210 км байдаг нь 4710 км урт Хятад Монголын хилийн 68,7 хувийг эзэлдэг. Газарзүй, соёлын давуу талд түшиглэсэн хоёр талын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа хурдтай хөгжиж Хятад, Монголын хоорондын нийт худалдааны эргэлтийн 50 гаруй хувийг эзэлдэг. Энэ утгаараа ӨМӨЗО, Монгол Улсын хоорондох соёл хүмүүнлэг, газарзүйн давуу талыг түшиглэж, Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны гүүр болох боломжтой юм.

Дүгнэлт, санал

Хятадын шинэ удирдагч Си Жинпины гадаад бодлого өмнөх үеийн аядуу зөөлөн бодлогоос эдийн засгийн эрчимтэй хөгжлийн хандлагаа даган санаачилгатай, прагматик бодлого болон өөрчлөгдөж байгаа нь дэлхий нийтэд **“Хятадын аюул”** хэмээх үзэл хүчтэй дэлгэрэхэд нөлөөлж байна. Үүнийг сөргүүлэн Хятад хөрш орнууддаа **“хөршөө хөгжүүлэх, хөрштэйгээ түншилэх”** бодлогыг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн дипломат бодлогын зээл, хөрөнгө оруулалт зэрэг “эер татах” эдийн засгийн бодлогыг ажилттай хэрэгжүүлж байна.

Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн эрчимтэй хөгжлийг улам бататган чанаржуулахын тулд **“стратегийн түншлэлийн харилцаа”**-г бодитоор хэрэгжүүлэхэд дараахи зүйлд түлхүү анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

1. Хоёр талаас нийгэм, соёлын ялгаатай байдлаас улбаатай зөрчлийг арилгах, итгэлцлийг бэхжүүлэх хүмүүнлэгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь туйлаас чухал байна. Нүүдлийн мал аж ахуйн талаар судлах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх, газар тариалангийн соёл, нүүдлийн мал аж ахуйн соёлын ялгаатай байдлыг эерэг талаас нь судлах болохоос бодлогогүйгээр үгүйсгэх, үл тоомсорлох аргыг хэрэглэх ёсгүй. Хятад, Монголын улс төр, худалдаа, эдийн засгийн харилцаанд хурдасгуурын (катализаторын) үүргийг гүйцэтгэх соёлын харилцааг дутуу үнэлж болохгүй юм.

2. Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаанд газар зүйн байршил, эдийн засгийн хөгжил суурь нөхцлийг бүрдүүлэгч 26 Д.Шүрхүү., “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал ба БНХАУ-ын хүчин зүйл” Стратеги судлал., №

болох газар зүйн байршил, эдийн засгийн харилцан нөхөх давуу талууддаа түшиглэн эдийн засгийн харилцааг тэнцвэржүүлэхийн тулд төмөр замын гарцын асуудлыг яаралтай Монголын талаас шийдвэрлэх нь чухал байна. Эдийн засгийн бодит үр өгөөж талаас нь асуудлыг харж “хэт улстөржих” хандлагаас зайлсхийх нь чухал.

3. Байгаль, экологийн асуудлыг хоёр талаас түлхүү анхаарч хамтран ажиллах шинэ арга хэлбэрийг нэвтрүүлэх шаардлагатай байна. Экологийн сөрөг үр дагавар нь хоёр талд аль алинд шууд нөлөөлөх учраас зохион байгуулалт, технологи, хөрөнгө оруулалт талаас нь хамтарч ажиллах шаардлага тулгарч байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Алтан., “Хятад, Монголын уул уурхайн харилцан ашигтай хамтын ажиллагааны талаархи зарим саналууд” МУИС-ийн ОУХС-аас зохион байгуулсан “Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ-д тавьсан илтгэл., 2013 оны 4 сар
2. Алтанбулаг., “Нийгэм, байгаль орчинд үзүүлж буй орон нутгийн аж үйлдвэржилтийн нөлөө, авч буй арга хэмжээ” МУИС-ийн ОУХС-аас зохион байгуулсан “Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ-д тавьсан илтгэл., 2013 оны 4 сар
3. Б.Отгонбаатар., “Хятадын эрчим хүчний аюулгүй байдал ба импортын хамаарал” Олон улс судлал сэтгүүл., 2013 №1 (98) х.48, 52
4. Б.Санжмятав., “Монголын уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт ба олон улсын эрх зүй” Олон улсын харилцаа сэтгүүл., 2013№1 х.
5. Б.Хөгжилт., “Хятад, Монголын уул уурхайн хамтын ажиллагааны суурь нөхцөл ба өнөөгийн байдлын анализ” МУИС-ийн ОУХС-аас зохион байгуулсан “Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ-д тавьсан илтгэл., 2013 оны 4 сар
6. Б.Хөгжилт., “Хятадын гадагш хөрөнгө оруулалт ба Монгол дахь хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, хүчин зүйл”
7. Б.Энхтүвшин, А.Даваасүрэн., “Монгол, ОХУ, БНХАУ: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа”
8. Д.Уламбаяр., “Монгол улсын геополитикийн орчны хувьсал: дүн шинжилгээ, эрсдлийн магадлал” Олон улсын харилцаа сэтгүүл.,

2013№1 х.

9. Д.Шүрхүү., “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал ба БНХАУ-ын хүчин зүйл” Стратеги судлал., №
10. Д.Шүрхүү., “XXI зууны эхэн үеийн БНХАУ-ын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа”
11. Д.Шүрхүү., “XXI зууны эхэн үеийн Монгол-Хятадын харилцаа: шинэ боломж, шинэ сорилт” Стратеги судлал
12. И Фон Чи., “БНХАУ-ын нүүрс үйлдвэрлэлийн хөгжлийн хандлага” Стратеги судлал., х.57-63
13. Хуан Жякүй., “Шинэ цагийн Хятад-Монголын харилцаа” МУИС-ийн ОУХС-аас зохион байгуулсан “Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа” сэдэвт ОУЭШХ-д тавьсан илтгэл., 2013 оны 4 сар
14. Ц.Батбаяр., “ХКН-ын XIII их хурлаас 2020 он гэхэд дундаж чинээлэг нийгэм байгуулах зорилт дэвшүүллээ”. Олон улс судлал сэтгүүл., 2013 №1 (98) х.6 /5-10/
15. Ч.Батцэцэг., “ХКН-ын XIII Их хурал болон Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаархи Оросын эрдэмтэн судлаачдын байр суурь”. Олон улс судлал., 2013 №3 х.5-21
16. Чанг Бин., “БНХАУ, Монгол улсын харилцаа, Хятад улсаас Монгол улсын талаар явуулж буй бодлого” Стратеги судлал